

**АМЬД БИЕ АМЬДРАЛЫН ОРЧИН:
Амьд биеийн үндсэн шинж**


Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Хүүхдүүд ээ. Хүн төрөлхтөн бид нэгэн төрлийн амьд бие шүү дээ. Хүмүүс бидэнд болон бусад амьд биесэд амьдрахад нь зайлшгүй шаардлагатай ямар хүчин зүйлүүд байдаг вэ?

Даалгавар

- 1 Надад болон миний хайртай гөлгөнд амьдрахад **зайлшгүй** шаардлагатай **амин чухал** зүйлсийг холбон зураарай.




- 2 Дээрх даалгавраас амьд биесийн ерөнхий шинж юу болохыг эргэцүүлэн бодоод дараах өгүүлбэрийн утгад тохирох үгсийг зөв сонгон бичээрэй.

Сонгох үгс: **том болох, хөдлөх, амьсгалах, хооллох, үржих, ялгаруулах**

Бүхий л амьд биес нь агаараар, усаар ундаалж ,шимт бодисоор, өсөж, үр удмаа үлдээн олон болж, идэш тэжээлээ олж идэх ба биеэ хамгаалахын тулд, биед хэрэггүй зүйлийг зэрэг шинжүүдтэй байдаг. Амьд бие бүр өөрийн онцлогт тохирсон амьдрах орчинтой байдаг.

- 3 Ургамал ба амьтанд амьдрах болон өсөх хөгжихөд нь хэрэгтэй зүйлсийг Эйлер- Веннийн диаграммд байрлуулаарай.




Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Амьд бие бүхэн амьдрах орчиндоо зохилдсон байдаг. Учир нь тэд амьдрах орчноосоо хоол тэжээл, амьсгалах агаар зэрэг амьдралын үйл ажиллагааг тэтгэх зүйлээ авч байдаг. Янз бүрийн орчин нөхцөлд ургадаг ургамал ялгаатай байх уу?

Даалгавар

1 Ургамал ургахад хэрэгтэй зүйлсээ ямар эрхтнээрээ дамжуулан амьдрах орчноосоо хүлээн авдаг вэ? Эргэцүүлэн бодоод холбон зураарай.



- агаар
- нарны гэрэл
- эрдэс бодис
- ус, чийг

2 Ургамлын эрхтэн нь ямар газар нутагт оршин байгаагаас шалтгаалан өөр байж болох уу? Энэ асуултад хариулахыг тулд манай орны байгалийн бүсүүдийн онцлогийг санацгаая. Зөв утгатай тохируулан холбоорой.

Байгалийн бүс

Уур амьсгалын онцлог

Ургамлын дасан зохицох шинж

Ой тайга	Хур тунадас маш бага ордог хуурай, халуун	Навчийн гадаргуу том
Говь цөл	Хур тунадас ихтэй, чийглэг сэрүүн, нарны гэрэл бага тусдаг	Навчийн гадаргуу жижиг

3 Дараах ургамлууд **говь цөл, хээр тал, ой тайга** зэрэг байгалийн аль бүсэд ургадаг болохыг нэрлээд учрыг тайлбарлан бичээрэй.



.....

Гоёо.....

.....

.....

.....



Хээр тал

Таана.....

.....

.....

.....



.....

Халиар.....

.....

.....

.....





АМЬД БИЕ АМЬДРАЛЫН ОРЧИН:
Амьтад орчиндоо зохицох нь






Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Амьд бие бүхэн амьдрах орчиндоо зохилдсон байдаг. Халуун орны амьтад хүйтэн сэрүүн оронд амьдарч чадах болов уу? Болохгүй гэвэл яагаад вэ? гэсэн асуултыг өөртөө тавин дараах дасгалуудыг ажиллаарай.

Даалгавар

1 Дараах амьтдын нэрийг нь бичээд амьдралын орчинтой нь зөв холбоорой.



2 Эдгээр амьтад амьдрах орчиндоо зохилдсон биеийн бүтцийн болон зан авирын ямар зохилдолгоо байна вэ? Сайтар эргэцүүлэн бодоод хүснэгтийг нөхөн бичээд зааврын дагуу тэмдэг тавиарай.

Амьтны шинж	Юунд зохицсон болох	Биеийн бүтцийн зохилдолгоо	Зан авирын зохилдолгоо
Тэмээний тавхай өргөн, том байдаг.	✓	
Тэмээ хоёр бөхтэй байдаг.	их хэмжээний ус нөөцлөхөд		
Анаашны хүзүү нь урт байдаг.		
Тоншуулын хошуу нь хурц , үзүүртэй	хоол тэжээлээ олж идэхэд		
Азарга үргэлж адуун сүргийнхээ урд явдаг.		
Гүрвэлийн өнгө нь хувирдаг.		
Сармагчингийн сүүл урт байдаг.	модонд дүүлж хоолоо олоход		
Оцон шувуунууд их хүйтэнд тэврэлддэг.		
Тарвага хошхирдог.	аюул ирэхэд бусдадаа дохио өгөхөд		

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:



Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр цаг



Амьтан бүрийн идэш тэжээл өөр өөр байдаг. Зарим нь ургамлаар хооллож байхад зарим нь өөрийн орчинд амьдардаг ямар нэг амьтнаар хооллодог шүү дээ. Амьтдыг идэш хоолоор нь хэрхэн ангилах вэ? Хүн төрөлхтөн бид ямар идэштэн бэ? Эргэцүүлэн бодоод дараах дасгалыг ажиллаарай.

Даалгавар

1 Манай орон нутагт амьдардаг бидний сайн мэдэх эдгээр амьтад идэш тэжээлээ хэрхэн олж иддэгийг санаарай.

Амьтдыг ямар идэштэн болохыг тодорхойлоод ✓ тэмдгээр тэмдэглээрэй. Дараа нь эдгээр амьтдаас нэг нэгэнтэйгээ идэш тэжээлээрээ холбоотой амьтдыг нэрлээрэй. / Жишээг хараарай /


Амьтны нэр	Өвсөн идэшт	Махан идэшт	Элдэв идэшт
чоно			
Хонь			
баавгай			
туулай			
Үнэг		✓	
зэрлэг гахай			

Чоно → хонь
.....
.....
.....
.....
.....

2 Дээрх даалгавраас харахад ихэнх махан идэштний хоол тэжээл нь голдуу өвсөн идэштэн байна. Дараах өгүүлбэрийн дутуу орхисон үгийг нөхөж бичээрэй.

Нэг орчинд амьдардаг амьд биес хоорондоо идэш тэжээлээрээ холбоотой байдаг. Үүнийг гэж нэрлэнэ. Идэш тэжээлийн хэлхээ бүр ногоон ургамлаар эхэлнэ.

3 Өгөгдсөн амьд биесийг идэш тэжээлийн холбоогоор нь зөв байрлуулсан эсэхийг ажиглаарай. Хэрэв буруу гэж үзвэл идэш тэжээлийн хэлхээг зөв дараалалд оруулж бичээрэй. **ногоон ургамал, мэлхий, тогоруу, эрвээхэйн авгалдай, хэдгэнэ, бүргэд**



Ногоон ургамал → → → → →

Дууссан: он сар өдөр цаг

☑ Өөрийн үнэлгээ: 🟡 🟡 🟡



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Энэ дэлхий дээр амьдран байгаа бүх амьд биесүүд хоорондоо харилцан шүтэлцээтэй оршин байдаг. Хэрэв аль нэг амьд бие устаж үгүй болбол бусад амьд биесэд хэрхэн нөлөөлж болох вэ?

Хүмүүс бидний буруугаас байгалийн тэнцвэрт байдал хэрхэн алдагдаж байгааг мэдэх үү?

Даалгавар

1 Хүн байгальд ямар сөрөг нөлөө үзүүлдэг бол дээрх QR кодыг уншуулан, дүрс бичлэгийг үзэж, бичлэг дээрх хүний сөрөг үйл ажиллагааг жагсаан бичээрэй.

.....
.....
.....
.....
.....



2 Хүмүүсийн хийдэг эдгээр буруу үйл ажиллагаанаас болж ургамал, амьтанд нөлөөлж болон нөлөөллөөс тус бүр 4-ийг тоочин бичэээй.



.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

.....
.....
.....
.....

3 Танай орон нутагт хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас болж ховордож байгаа ургамал, амьтан байгаа юу? Эдгээр амьд биеийг хамгаалахын тулд бид юу хийвэл зохих вэ? Аав , ээж , ах эгчтэйгээ хамтран ярилцаад бичээрэй.

.....
.....
.....
.....
.....

Дууссан: он сар өдөр цаг



Өөрийн үнэлгээ:

